

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

Малын үндэсний генийн санд үржүүлгийн бүтээгдэхүүнийг
байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих журам
батлах тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 15.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Малын үндэсний генийн санд үржүүлгийн бүтээгдэхүүнийг бэлтгэх, бүртгэх, байршуулах, зарцуулах, хяналт тавих журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д. Батмөнх/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Хуулийн хэлтэс /Э.Цолмонжаргал/-д даалгасугай.

САЙД

З.МЭНДСАЙХАН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2021 оны ... дугаар сарын ...-ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

МАЛЫН ҮНДЭСНИЙ ГЕНИЙН САНД ҮРЖҮҮЛГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БАЙРШУУЛАХ, БҮРТГЭХ, ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.4.-д заасны дагуу “**малын үржүүлгийн бүтээгдэхүүн**” гэж малын удамшлын мэдээлэл агуулсан ДНХ, РНХ, биеийн эс, өндгөн эс, үр, хөврөл, сорьц болон бусад бүрэлдэхүүнийг хэлнэ.

Зорилго: Монгол улсад үржүүлж буй үүлдэр, үүлдрийн хэсэг, омог хэвшлийн малын удмын санг хамгаалах, ашиг шим арвинтай мал амьтны үржүүлгийн бүтээгдэхүүнийг ашиглах хамгаалах, дээж, сорьцыг байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хамрах хүрээ: Энэхүү журам нь мал, амьтны үндэсний генийн санг бүрдүүлэн хадгалж байгаа төрийн үйлчилгээний төв байгууллага, цөм сүргийн үржлийн төв, донор аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль болон Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж буй дотоод гадаадын хөрөнгө оруулалттай эрчимжсэн аж ахуй эрхлэгчид, үржлийн бүтээгдэхүүн импортлох, экспортлох тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад хамааралтай.

ХОЁР. ҮРЖҮҮЛГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БЭЛТГЭХ

2.1. Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй, удам зүйн үнэлгээ хийгдсэн төрөл бүрийн мал амьтнаас үр, хөврөл, өндгөн эс, ДНХ, РНХ, биеийн эс, сорьцыг бэлтгэнэ.

2.2. Үржүүлгийн бүтээгдэхүүнийг тусгай зөвшөөрөлтэй, эрх бүхий генетик нөөцийн төв, эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургууль, цөм сүргийн үржлийн төв, донор аж ахуй бэлтгэнэ.

2.3. **Төрөл бүрийн мал амьтны үр бэлтгэх:** Хээлтүүлэгч мал амьтнаас зохиомол үтрээ ашиглан үрийг авч чанарын үнэлгээ өгөн зориулалтын шингэлэгчээр шингэлж, стандартын шаардлага хангасан үрийг технологийн дагуу гүн хөлдөөнө.

2.4. **Төрөл бүрийн мал амьтнаас хөврөл бэлтгэх:** Төрөл бүрийн дааврын хувилбар ашиглан донор мал амьтаны өндгөвчинд өндгөн эс олноор ялгаруулан ердийн болон зохиомол хээлтүүлэг хийж үр тогтоон, хөврөлийг мэс заслын болон мэс заслын бус аргаар зайлан авч хэлбэр зүй, хөгжлийн үнэлгээний шаардлага хангасан хөврөлийг технологийн дагуу бэлтгэнэ.

2.5. **Хээлтэгч, мал амьтнаас өндгөн эс бэлтгэх:** Мал нядалгааны газарт нядалгаанд орж буй хээлтэгч малын шинэхэн өндгөвчөөс болон өндгөн эс олноор ялгаруулсан амьд мал амьтдын савны эврээс зориулалтын шингэн ашиглан зайлж авах, эсвэл тусгай зориулалтын багаж ашиглан өндгөвчин дээр үүссэн уутанцраас соруулж (ОРУ) авах аргаар өндгөн эсийг бэлтгэнэ.

2.6. ДНХ, РНХ бүхий удамшлын материал бэлтгэх: ДНХ гэдэг нь амьд бие махбодын удамшлын мэдээллийг хадгалах, үр удамд дамжуулах, нөхөн үйлдвэрлэх үүрэгтэй нуклейн хүчил юм. Төрөл бүрийн мал амьтны цус, үс, ноос ноолуур, үрнээс ДНХ-г олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн энгийн аргаар болон төрөл бүрийн kit ашиглан ялган авна.

2.7. Биеийн эсийн биопси бэлтгэх: Амьд болон үхсэн амьтны биеийн эд эртхтэнээс биеийн эсийн шинэхэн биопси бэлтгэх зааврын дагуу бэлтгэнэ.

Гурав: Үржүүлгийн бүтээгдэхүүний тэмдэглэгээ

3.1. Малын үрийг ялган тэмдэглэх

3.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр төрөл бүрийн малын шилмэл хээлтүүлэгчээс үр авч шингэлэн гүн хөлдөөх тохиолдолд тухайн үрийн гуурс тус бүр дээр энэхүү журмын 3.1.2-д заасны дагуу ялган тэмдэглэгээг заавал хийнэ;

3.1.2. Удам зүйн үнэлгээ хийлгэсэн малаас бэлтгэсэн үржүүлгийн бүтээгдэхүүн нь тэмдэглээтэй байна. Тэмдэглэгээ нь улсын код, байгууллагын код, тухайн малын үүлдрийн код, хээлтүүлэгчийн хувийн дугаар, үр авсан огноо, үрийн серийн дугаар гэсэн дараалалтайгаар бичигдэнэ;

3.1.3. Үржүүлгийн бүтээгдэхүүн бэлтгэх, байршуулах, хөлдөөх, түүнийг түгээх эрх бүхий байгууллага нь хээлтүүлэгчээс үр авах ариун цэвэр эрүүл ахуй, биоаюулгүй байдлын шаардлагыг зохих журам, зааврын дагуу хангасан, үрийг авах, бэлтгэх, ичээх, гүн хөлдөөх, хадгалах, тээвэрлэх чиглэлээр мэргэшин хүлээн зөвшөөрөгдсөн, удирдлага, хяналттай байгууллага байна;

3.1.4. Монгол улсын нутаг дэвсгэр дээр цэвэр үүлдэр, омгийн малын хээлтүүлэгчээс үр авах, бэлтгэх, хөлдөөх, түүнийг түгээх төв байгууллага болон энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах бусад байгууллагууд нь энэхүү журмын 7 дугаар хавсралтад заасны дагуу тодорхойлон кодлогдоно;

3.1.5. Малын үүлдэрлэг байдал, сүргийн кодыг энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу бүртгэнэ. Үүлдрийн болон сүргийн кодыг дангаар нь эсвэл нэг бүрдэл тэмдэглэгээ байдлаар хэрэглэж болно. Шаардлагатай тохиолдолд хавсралтанд нэмэлт оруулах замаар тэмдэглэгээг нэмж болно;

3.1.6. Хээлтүүлэгчийн хувийн дугаар нь энэхүү журмын 2.1.5- 2.1.6 дугаар зүйлд заасны дагуу ялган тэмдэглэгдсэн байна;

3.1.7. Үр авсан огноог YY/OO.XX гэсэн формат хэлбэрээр хэвлэнэ. Үүнд: YY/ - тухайн оны сүүлийн 2 орон (10 эсвэл 11 гэх мэт) ташуу зураас, OO - тухайн сарын 2 орон (05 эсвэл 12 гэх мэт) цэг, XX – тухайн өдрийн 2 орон (08 эсвэл 25 гэх мэт) байна;

3.1.8. Үрийн серийн дугаарыг нэмэгдэл мэдээлэл гэж үзэх бөгөөд хэвлэхдээ тухайн огнооны дараа ташуу зураасаар зааглан нэмж оруулна. Үүнд: "YY/OO.XX/15" гэх мэт;

3.1.9. Үрийн гуурсан дээрх хэвлэлт нь мэдээллийг харагдахуйц тод байлгах нөхцлийг хангасан байх ёстой;

3.1.10. Үрийн гуурсан дээрх тэмдэглэгээнээс өгөгдлийн санд "үр бэлтгэгчийн улс орны гарал, хээлтүүлэгчийн үүлдэр, хувийн дугаар" зэргийг онцлон үзэх бол малын үржүүлгийн техникч "хээлтүүлэгчийн үүлдэр, хувийн дугаар, үр бэлтгэсэн огноо, серийн дугаар"-ыг онцлон тэмдэглэж авна;

3.1.11. Үрийн гуурсан дээр тэмдэглэсэн кодыг тухайн төрлийн малын үүлдэр олон улсын кодын жагсаалтад орсон эсэхээс хамааран улсын гарал үүсэл болгон шууд хэрэглэж болно;

3.1.12. Олон улсын жагсаалтад орсон үүлдэртэй нэр давхардахгүй, бие даасан үүлдэр болох нь тогтоогдсон үүлдрийн шилмэл хээлтүүлэгчээс 10000-аас доошгүй тун үрийг 3-аас дээш оронд экспортолсон тохиолдолд тухайн үүлдрийг олон улсын ялган тэмдэглэгээний кодын жагсаалтад гарал үүслийн орноор бүртгүүлэх хүсэлтийг Олон улсын мал, амьтны бүртгэлийн хороонд албан ёсоор холбогдох журмын дагуу гаргаж болно;

3.1.13. Дээрх тоо нь олон улсын шинэчлэгдсэн журмын дагуу өөрчлөгдөж болно;

3.1.14. Олон улсын үүлдрийн кодын жагсаалтад үүлдрийн гарал үүслийг өөрийн орноор бүртгүүлсэн тохиолдолд тухайн үүлдрээс үйлдвэрлэсэн үрийн тунгийн тоо, экспортод гаргасан тунгийн тоо зэрэг удамшил зүйн материалын талаар олон улсын хэмжээнд харилцан солилцох үүрэг хүлээнэ.

3.2.Малын хөврөл үрийг ялган тэмдэглэх

3.2.1. Янз бүрийн нөхцөл байдлын улмаас хөврөл үрийн гарал үүсэлтэй холбоотой түүхийг мөшгин судлах, ашиглах, мэдээллийн санг бүрдүүлэхэд хэрэглэх зориулалтаар малын хөврөл үрийн талаарх мэдээллийг заавал бүртгэнэ;

3.2.2. Хөврөл үрийн гуурс тус бүр дээр тухайн хөврөл үрийн талаархи мэдээллийг харуулсан лавлагаа дугаарыг хэвлэсэн байна;

3.2.3. Лавлагаа дугаарт тухайн хөврөл үрийг бэлтгэсэн байгууллагын код, гардан гүйцэтгэгч багийн ахлагчийн код, хөврөл үрийг угааж авсан хээлтэгчийн үүлдрийн код, хувийн дугаар, хөврөл үрийг бүрдүүлэгч хээлтүүлэгчийн үүлдрийн код, хувийн дугаар, хөврөл үрийг бэлтгэсэн он, сар, өдөр, хөврөл үрийн серийн дугаар, хөврөл үрийн нас, хөлдөөлтийн огноог тус тус бичнэ;

3.2.4. Лавлагаа дугаарт тухайн захиалагч болон үржүүлгийн байгууллагын шаардлагаар өөр бусад мэдээлэл нэмж оруулж болно;

3.2.5. Хөврөл үрийг угааж авах, хөлдөөх үед уг ажиллагааг ахлан гүйцэтгэгчийн талаархи тодорхойлолтыг тусгайлан авч бүртгэн, код олгоно;

3.2.6. Төрөл бүрийн малын хөврөл үрийг зайлж авах, хөлдөөх, шилжүүлэн суулгах ажиллагааг мэргэшсэн эрдэмтэд, судлаачид, мал зүйч, малын эмч, нөхөн үржүүлгийн техникч нар дангаар эсвэл багаар гүйцэтгэх бөгөөд багийн ахлагч лавлагаа бүртгэлээ төрийн захиргааны төв байгууллагад өгч, кодоо авна;

3.2.7. Гардан гүйцэтгэгч багийн ахлагчийн код нь харъяаллын байгууллагын кодын дараа бичигдэнэ;

3.2.8. Хөврөл үрийн гарал үүсэлтэй холбоотой мэдээллийн санд хөврөл үрийг бэлтгэсэн донор хээлтэгч, хээлтүүлэгчийн үүлдрийн код, хувийн дугаар, ашиг шимийн үзүүлэлт, хөврөл үрийг угааж бэлтгэсэн, хөлдөөсөн, генийн санд хадгалсан, импортолсон, ашигласан огноо, тээгчид шилжүүлэн суулгасан огноо, хөврөлийн нас, хөврөл үрийг шилжүүлэн суулгасан ажилбарын төрөл, тээгчийн хувийн дугаар зэрэг өгөгдлийг бүртгэнэ;

3.2.9. Хөврөл үрийг экспортлох зорилгоор гарган авсан нөхцөлд ялган тэмдэглэгээг Мал, амьтны бүртгэлийн Олон улсын хорооноос гаргасан үүлдрийн кодын жагсаалтын дагуу хийнэ;

3.2.10. Тухайн жагсаалтад ороогүй үүлдрийн малаас хөврөл үр бэлтгэж буй тохиолдолд энэхүү журмын 2.1.5, 2.1.6-д заасны дагуу ялган тэмдэглэгээг хийнэ;

3.2.11.Импортолсон хөврөл үртэй холбоотой өгөгдлүүдийг дагалдах баримт бичигт үндэслэн авах ба хөврөл үрийг импортлох, борлуулах үед цаасан болон цахим мэдээлэлд байгаа үзүүлэлтийг хөврөл үрийн гуурсан дээрхи тэмдэглэгээтэй харьцуулан үзэж гарал үүслийг баталгаажуулна;

3.2.12. Хөврөл үр шилжүүлэн суулгах замаар гарсан төлийн гарвалийг тодорхой болгохын тулд удамшлын эх болон биологийн эх хоёрын хоорондох ялгааны бүртгэлийг хөврөл үр шилжүүлэн суулгах үед холбогдох баримт бичигт заавал тэмдэглэнэ;

3.2.13.Хөврөл үрийг угааж авах, хөлдөөх, хадгалах, шилжүүлэн суулгах зэрэг ажилбар бүрийн гүйцэтгэсэн огноог анхан шатны бүртгэлд тэмдэглэж байна;

3.2.14. Хөврөл үр бэлтгэн авах, шилжүүлэн суулгахад ашиглагдах донор болон тээгч малыг шилэн сонголтын үндсэн дээр сонгож, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн тусгай нөхцөлд тэжээллэг, арчилгаа маллагааны технологийн дагуу байлгана;

ДӨРӨВ. ҮРЖҮҮЛГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БҮРТГЭХ

4.1. Үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, экспортлох, үйлчилгээнд нэвтрүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж, олон улсын байгууллага нь “Малын генетик нөөцийн тухай” хуулийн 15.1-д заасаны дагуу төрийн захиргааны төв байгууллагад бүртгэлтэй байна.

4.2. Стандартын шаардлага хангасан үржлийн бүтээгдэхүүнийг серийн дугаараар улсын бүртгэлд бүртгэгдэнэ.

4.3. Гадаадаас авсан үржүүлгийн бүтээгдэхүүнийг олон улсын тэмдэглэгээний дагуу генийн санд тусгайлан бүртгэж авна.

4.4. Гадаадаас оруулж ирсэн үржүүлгийн бүтээгдэхүүний савлагаан дээрхи тэмдэглэгээнээс өгөгдлийн санд “бэлтгэгч улс орны гарал, хээлтэгч хээлтүүлэгчийн үүлдэр, хувийн дугаар” болон операторчийн хувийн дугаар, бэлтгэсэн огноо, серийн дугаар”-ыг тусгайлан тэмдэглэн авна.

4.5.Малын удам гарвалийн нарийвчилсан хянан баталгааг хийхдээ тэдгээрээс цусны эсвэл эд, эсийн дээж авч, цусны бүлгийн тохирлоор болон ДНХ-ийн шинжилгээгээр тодорхойлно;

4.6.Хөврөл шилжүүлэн суулгах аргаар гарсан төлийн удамшилтыг энгийн аргаар тооцохдоо хөврөл шилжүүлэн суулгасан болон хээлтэгчийн төрсөн үеийн хугацааг тухайн төрлийн малын хээл тээлтийн хугацаа, хөврөлийн настай харьцуулан үзнэ;

4.7.Хээлтүүлэгчийн болон арвин ашиг шимт шилмэл малын гарвалийг зөвхөн ДНХ-ийн шинжилгээгээр баталгаажуулна

4.8.Бүртгэлийн анхан шатны нэгж буюу сум, дүүргийн мал эмнэлэг, үржлийн тасаг болон малын удмын санг хамгаалах асуудал эрхэлсэн байгууллага нь малын үржүүлгийн бүртгэлийг хөтлөхийн тулд энэхүү журмын 4.1.2-д дурьдсан бүртгэл хөтлөгчөөс мэдээллийг цуглуулан бүртгэлийг хийнэ;

4.9.Бүртгэл хөтлөгч нь мал үржүүлэгт орсон тухай тэмдэглэгээг тухайн өдөрт нь хувийн тэмдэглэгээ хийх замаар бүртгэж, дараа нь холбогдох маягтын дагуу бүртгэлийн анхан шатны нэгжид мэдээгээ хүргүүлнэ;

4.10.Бүртгэлийн тэмдэглэлд хээлтүүлгийн төрөл /ердийн эсвэл зохиомол/, огноо, хээлтэгч, хээлтүүлэгч малын ялган тэмдэглэгээн дэх хувийн дугаар, нэр хоч, зүс, зохиомол хээлтүүлэг хийсэн тохиолдолд техникчийн нэр, код зэргийг бичнэ;

4.11.Хөврөл шилжүүлэн суулгасан тохиолдолд донорын болон хээл тээгчийн талаарх мэдээллийг бүртгэнэ;

4.12.Малын эзэн, малчин нь шинээр гарсан төлийн хүйс, зүс, эхийн хувийн дугаарыг төллөсөн өдөрт нь тэмдэглэн авч хариуцсан мэргэжилтэн, харъяаллын нэгжид тухайн сардаа мэдэгдэж байна;

4.13.Шинээр гарсан төлд 7-30 хоногийн дотор ялгах тэмдэглэгээг хийж, гэрчилгээг шинээр нээнэ;

4.14.Зохиомол хээлтүүлгийн бүртгэлийг мэргэжлийн байгууллага, түүний салбар эсвэл малын үржүүлгийн техникч бүртгэлийн нэгжид гаргаж өгөх үүрэгтэй;

4.15.Зохиомол хээлтүүлгийн нэгдсэн бүртгэлд гүн хөлдөөсөн үрийг түгээгч байгууллагын код, зохиомол хээлтүүлэгт ашигласан хээлтүүлэгчийн үүлдрийн код, хувийн дугаар, хээлтүүлэг хийсэн огноо, техникчийн код, хээлтэгчийн хувийн дугаар, үрийн гуурсны сериал дугаар, зохиомол хээлтүүлэг давтагдсан байдал, хээлийг шалгасан огноо, хээл авалтын байдал зэрэг өгөгдлүүдийг тэмдэглэнэ;

4.16.Бэлгийн нэг мөчлөгийн хугацаанд хийсэн зохиомол хээлтүүлэг нийт хэдэн удаа давтагдсаныг бүртгэлийн огноогоор тодорхойлох ба эхний зохиомол хээлтүүлэг 1 гэсэн тоогоор илэрхийлэгдэнэ. Түүнээс хойш давтагдсан байдал нэг нэгээр нэмэгдэн дугаарлагдах ба зохиомол хээлтүүлгийг давхар хийсэн тохиолдолд давтагдсан байдлын тоо өмнөхтэйгээ адил буюу өөрчлөгдөхгүй байна;

4.17.Ердийн хээлтүүлгийн талаар бүртгэл хийхдээ хээлтэгчийн үржилд орсон огноо, хээлтэгчийн болон хээлтүүлэгчийн хувийн дугаар, үүлдрийн код, ороо давтагдсан байдал зэрэг өгөгдлүүдийг тэмдэглэнэ;

4.18.Үржүүлгийн бүртгэлийг цаасан хэлбэрээр тэмдэглээд дараа нь мэдээллийн сангийн өгөгдөл болгон программд оруулж болно;

4.19. Үржүүлгийн тухай өгөгдлийн үнэн зөв эсэхийг бүртгэгдсэн мал тус бүрийн тухай өмнөх өгөгдлийн үзүүлэлттэй харьцуулан шалгаж баталгаажуулна. Тухайлбал, хээлтэгчийн ялгах тэмдэглэгээний хувийн дугаар нь харъяалалтайгаа тохирч байгаа эсэх, хээлтэгч нь үржилд ашиглахад тэнцэхээр насанд хүрсэн эсэх, хээлтэгчийн хээл тээсэн ба ороо орсон хугацаа нь тухайн төрлийн малын физиологийн хугацаатай тохирч байгаа эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулна;

4.20. Ердийн хээлтүүлгээр үржүүлэгт орсон малын үржүүлгийн тухай бүртгэлийг хянан баталгаажуулахдаа дараах шалгалтыг хийнэ. Үүнд: тухайн малын сүргийн ба үүлдрийн код тохирч байгаа эсэх, хээлтэгч, хээлтүүлэгчийн ялгах тэмдэглэгээний хувийн дугаар харъяалалтайгаа тохирч байгаа эсэх, хээлтэгчийн үржилд орсон ба хээл тээсэн хугацаа тухайн төрлийн мал, амьтны физиологийн үзүүлэлттэй тохирч байгаа эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харьцуулан баталгаажуулна;

4.21. Малын үржүүлгийн өгөгдлүүдийг тухайн төрлийн малын төллөлтийн тухай мэдээллийн өгөгдлүүд ирэхээс өмнө бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулсан, дамжуулсан байх ёстой;

4.22. Мэдээллийн санд өмнө нь орсон малын үржүүлгийн бүртгэл одоогийн мэдээлэлтэйгээ хэрхэн уялдаж буйг бүртгэгч байнга харьцуулан баталгаажуулж байх ёстой;

4.23. Малын үржүүлгийн өгөгдлүүдийг удам зүйн үнэлгээний боловсруулалт хийх зориулалтаар зөвхөн мэргэжлийн байгууллага, баг ашиглана. Энэ тохиолдолд малын тухай мэдээллийг тухайн үнэлгээг гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн Малын бүртгэл, мэдээллийн үндэсний сангаас өгнө;

4.2.17. Малын зохиомол хээлтүүлгийн болон хөврөл үр, түүнийг шилжүүлэн суулгахтай холбоотой бүртгэлийн өгөгдлүүдийг удам зүйн үнэлгээнд ашиглахдаа олон удаагийн цуврал шалгалтанд оруулж баталгаажуулах тул анхан шатны бүртгэгч нар мэдээллийн үнэн зөвийг хариуцах үүрэгтэй;

4.24. Удам зүйн үнэлгээг хийхдээ зохиомол хээлтүүлэгт ашигласан хээлтүүлэгчийн ялган тэмдэглэгээний багц код нь Олон улсын кодтой уялдаж байгаа эсэхийг тодорхойлно;

4.25. Сүргийн удам зүйн сайжруулалтыг хийхдээ сүргийн болон үүлдрийн кодыг бүртгэлд баримтлах байдлаар явуулж болно;

4.26. Үндэсний хэмжээнд хийх малын удам зүйн үнэлгээг мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаач нар тодорхой арга зүйн дагуу хийж, үр дүнг олон нийтэд мэдээлсний дараа үнэлгээг албан ёсны гэж үзнэ;

4.27. Малын удам зүйн үнэлгээгээр үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч болон түүний үр төлийн тоо, тэдгээрийн сүрэг дэх тархалт, амьдрах чадвар, охин үр төлийн ашиг шимийн удамшилтын хувь зэргийг харьцуулан гаргах ба энэ тухай мэдээллээр малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг баяжуулан шинэчилж байна.

ТАВ. ҮРЖҮҮЛГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ БАЙРШУУЛАХ, ХАДГАЛАХ

5.1. Монгол мал, амьтныг мөхөх, устахаас сэргийлж хамгаалах зорилгоор үржүүлгийн бүтээгдэхүүний дээж, сорьц, цуглуулгыг бий болгож, генийн санд

байршуулан хадгалж, үндэсний генийн санг бүрдүүлэх ажлыг “Малын генетик нөөцийн тухай” хуулийн 15.1-д заасан байгууллага хариуцан ажиллана.

5.2. Гадаадад гаргаж байгаа үржүүлгийн бүтээгдхүүний төрөл, зүйл, цуврал тус бүрийн сорьцын ижил хувийг малын үндэсний генийн санд байршуулана.

5.3. Тоо толгой нь цөөрч, удмын сан нь алдагдах байдалд орсон мал, амьтдын удамшлын ялгаатай 20-25 толгой бод малын хээлтүүлэгч тутмаас чанарын шаардлага хангасан 4 баллаас дээш үнэлгээтэй 200 тун үр, бог малын хээлтүүлэгчээс 150 тун үр, Олон Улсын эталон ашиглан үнэлсэн үнэлгээгээр хэлбэр зүй, хөгжлийн хувьд маш сайн, сайн үнэлгээ өгөгдсөн бластоцитын шатны хөгжилтэй 35-аас доошгүй хөврөлийг хадгалана.

5.4. Үүлдэр омог, удам, бүл, зүйл, удам үүсгэгчдийн удмын санг хамгаалах зориулалтаар бэлтгэсэн үр, хөврөлийг -196°C -ийн шингэн азот бүхий зориулалтын саванд 20 жилээс доошгүй хугацаагаар, метафазийн II шатны хөгжилтэй өндгөн эс, биеийн эсийг 4 хүртэлх жилийн хугацаагаар, цэвэршил сайтай, ДНХ, РНХ, биеийн эсийн биопси, сорьцыг -20°C , -80°C , -196°C -т хуурай хэлбэрт оруулан урт хугацаагаар хадгалана.

5.5. Үржүүлгийн бүтээгдэхүүнийг малын үржүүлэг, биотехнологийн итгэмжлэгдсэн лабораторит мэргэшсэн оператор технологийн дагуу бэлтгэн генийн сангийн мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.

5.6. Үржлийн бүтээгдэхүүнийг бактерицидийн ламп бүхий хорио цээрийн хаалттай горимоор ажиллах байранд технологийн зааврын дагуу цельсийн -196 градусын шингэн азоттой бортгонд босоогоор нь хадгална.

5.7. Үржүүлгийн бүтээгдэхүүний генийн сан нь “Малын генетик нөөцийн тухай” хуулийн 15.1-д заасан төв байгууллага болон түүний харъяа бүсийн төв, салбар нэгжүүдэд хадгалагдана.

5.8. Үржлийн бүтээгдэхүүний цуврал бүрд гүн хөлдөөснөөс хойш 28 хоногийн дотор каринтинд байх хугацаанд бруцеллёз, вибриоз, трихомоноз, сүрьеэ, лейкоз өвчний шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор хийлгэж, эрүүл болохыг нь баталгаажсаны дараа генийн санд хүлээн авна.

5.9. Шинээр үржлийн бүтээгдэхүүнийг генийн санд байршуулахдаа танк тус бүрийг тусгай тэмдэглэгээр дугаарлан тухайн үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн /он, сар, өдөр/-ийг тэмдэглэж бортгонд байршуулна. Цаашид 6 сар тутам үнэлгээ өгч бүртгэлд бичнэ.

5.10. Хадгалах танк, контейнер савны дотрыг хагас жил тутам эталонор ариутгаж, ашигтай өндрийн гуравны хоёроос доошгүй түвшинд шингэн азотоор дүүргэнэ. Азотын түвшинг сар бүр шалгана.

5.11. Шингэн азотын сав (Дьюарын сав)-ны тагийг битүүмжилж болохгүй. Дьюарын савыг шалнаас дээш 20 см зайтай тавиур дээр байршуулна.

5.12. Үржлийн бүтээгдэхүүнийг хадгалах генийн сангийн өрөө нь 10 градус цельсээс бага температуртай, агааржуулалтын системд холбогдсон, амьсгал боох аюултай гэсэн анхааруулах тэмдэг бүхий хаалгатай, өрөөний хүчилтөрөгчийн хэмжээг хэмжих багажтай, бетонон шалтай, хана нь угааж цэвэрлэхэд хялбар,

шатамхай бус материалаар хийгдсэн, галын дохиололтой, нарны гэрлийн шууд тусгалгүй байх бөгөөд олон нийтийн амьдрах байрнаас зайтай байна.

5.13. Үржүүлгийн бүтээгдэхүүнийг хадгалж байгаа Малын генийн үндэсний сангийн байрны ариун цэвэр, технологийн нөхцлийг сар тутам шалгаж, тусгай бүртгэл хөтөлнө.

ЗУРГАА. ҮРЖҮҮЛГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЗАРЦУУЛАХ

6.1. Үржүүлэг технологийн ажил үйлчилгээний төрөл, төлбөрийн жишиг үнийг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн Газрын төв байгууллага батална.

6.2. Технологийн дагуу хадгалагдаж байгаа үр, хөврөлийг 5 жилд багтаан эрчимтэй зарцуулж, үр дүнг тооцож байх нь зүйтэй.

6.3. Генийн санд хадгалагдаж биеийн эс, өндгөн эсийг тэдгээрээс ДНХ, РНХ ялгаж авах, өндгөн эсийн цитоплазмд үр шахах, зохиомол орчинд үр тогтоох, клонингийн аргаар тухайн мал, амьтныг бий болгох зэрэгт ашиглана.

6.4. Төрөл бүрийн аргаар ялган авсан ДНХ-г молекул биологи, генийн инженерчлэлийн аргаар эм, антибиотикийн мэдрэг чанарыг тодорхойлох, удамшлын өвчнийг эмчилэхэд ашиглана.

6.5. ДНХ-ийн технологи буюу генийн санг ашиглан малын үүлдэр, омог, удмын холбоог тогтоох, устаж үгүй болох гэж буй мал амьтан, устаж үгүй болсон мал амьтныг дахин сэргээх, үржүүлэх, тэдгээрийн генийн санг хадгалахад ашиглана.

6.6. Малын амьтны үндэсний генийн санг чанарын шаардлага хангасан үржүүлгийн бүтээгдэхүүнээр жил бүр сэлбэн баяжуулана.

6.7. Энэ журмын 5.3–д заасан шаардлага хангаагүй үр, хөврөлийг заазалж, хадгалалтаас хасна. Үр, хөврөлийг хадгалалтаас хасч, заазлах асуудлыг зөвхөн Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Мал үржлийн улсын ерөнхий байцаагчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

6.8. Үндэсний генийн санд хадгалагдаж буй үржүүлгийн бүтээгдэхүүнийг хавсралт болгосон хүснэгт бүртгэлийн дагуу тусгай журналд бүртгэн зарцуулана..

6.9. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад захиалга, гэрээний дагуу үйлчлэхдээ авах гэж буй үржлийн бүтээгдэхүүнийг үнэлж, чанарын үнэлгээний маягт бичин, 2 тал гарын үсэг зурж баталгаажуулна.

ДОЛОО. ҮРЖҮҮЛГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ

7.1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, үржүүлгийн техникч үржүүлгийн бүтээгдэхүүнийг малын үржлийн стратеги төлөвлөгөөний дагуу үржүүлэг, технологийн ажил үйлчилгээг явуулахад “Малын генетик нөөцийн тухай” хуулийн 15.1-д заасан байгууллага хяналт тавин ажиллана.

7.2. Үржүүлгийн бүтээгдэхүүн байршуулж байгаа аж ахуй нэгж, байгууллага нь үржлийн бүтээгдэхүүнийхээ зарцуулалтын тайланг улирал бүр “Малын генетик нөөцийн тухай” хуулийн 15.1-д заасан байгууллагад өгнө.

7.3. Үржлүүлгийн бүтээгдэхүүнийг экспортлох болон импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж, байгууллага нь “Малын генетик нөөцийн тухай” хуулийн 15.1-д заасан байгууллагад бүртгүүлэн орон нутагт үржлийн ажил, үйлчилгээ явуулахаар бол гэрээ байгуулана..

7.4. Үржлүүлгийн бүтээгдэхүүнийг зарцуулсан аж ахуй нэгж, байгууллага, үржлүүлгийн техникчийн ажлын үр дүнг шалгахдаа жилд 2 удаа хээлийн шалгалт хийж, хээл авалтын хувийг тогтоож, үржлийн ажил үйлчилгээ явуулсан үржлүүлгийн техникчийн ажлыг мэргэжлийн байгууллага үнэлж дүгнэлт гаргана.

7.5. Малын үндэсний генийн санд хадгалагдаж буй үржлүүлгийн бүтээгдэхүүнээс хяналтын шинжилгээ хийх зорилгоор 6 сар тутам, 1-2-ыг сонгон тэдгээрийн идэвхи, чанар, хадгалалт хамгаалалтын технологийн горимыг үнэлнэ.

7.6. Малын үндэсний генийн санд байрших, үржлүүлгийн бүтээгдэхүүнийг байгалийн болон гэнэтийн давагдашгүй хүчин зүйл, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшгаас сэргийлсэн байранд хадгална.

Үржүүлгийн бүтээгдэхүүн хөврөлийг байршуулах,
бүртгэх, зарцуулах, хяналт тавих журмын хавсралт

ҮР ХӨВРӨЛИЙН ГЭРЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. ДОНОРООС ХӨВРӨЛ ЦУГЛУУЛЖ АВСАН ТУХАЙ ГЭРЧИЛГЭЭ

Хөврөл зайлж авах бүр гэрчилгээнд байгаа мэдээлэлийг бүрэн бүрдүүлнэ. Олон улсын стандартын дагуу тухайн донор малын бүртгэлийн дугаарыг бичихдээ улсын нэрийн гурван үсгээр товчилон тэмдэглэнэ. Хөврөл үйлдвэрлэлийг хариуцаж байгаа мэргэжилтэн тухайн донорын тухайн болон түүнээс гарсан хөврөлийн талаарх мэдээлэлийг үнэн зөв бөглөж гарын үсэг зурж баталгаажуулна.

ХӨВРӨЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Үүлдэр				
Донорын нэр, хоч		Дугаар		
Эзний нэр		Хаяг		
		Ороо орсон өдөр		
Техникчийн нэр		Хээлтүүлсэн хугацаа		
Хээлтүүлэг хийсэн үрийн хүйс	эр	эм	Хөврөл авсан огноо	
			авсан хөврөлийн тоо	
	доогуур зурна		үхсэн	
			үр тогтоогүй	
			шилжүүлэн суулгасан	
		хөлдөөж хадгалсан		
Гарын үсэг		аж ахуйн нэр		
		хөврөлийн код		

2 .ТЭЭГЧИД ХӨВРӨЛ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАСАН ТУХАЙ ГЭРЧИЛГЭЭ

Хөврөл шилжүүлэн суулгасан гэрчилгээ болон хөврөл зайлж авсан гэрчилгээг 2 хувь үйлдэж эх хувийг тухайн сум, дүүргийн ХАА-н тасгийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнд, харин хуулбар хувийг тухайн хөврөл суулгуулсан иргэн, аж ахуй нэгжид хүлээлгэн өгнө.

Хөврөл суулгаж гарсан төлийн бүртгэлийг тухайн малын эзэмшигч нь тухайн сум, дүүргийн ХАА-н тасгийн бүртгэлийн мэргэжилтэнд бүртгүүлнэ.

ХӨВРӨЛ ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАСАН ТУХАЙ ГЭРЧИЛГЭЭ

Шилжүүлжн суулгасан тухай ерөнхий мэдээлэл

Хөврөл шилжүүлэн суулгасан огноо		Арга	мэс заслын	мэс заслын бус	бусад
Доогуур зарна					

Гүн хөлдөөсөн хөврөл

Хөлдөөсөн огноо	
Техникчийн мэдээлэл	
Гуурсны дугаар	

Бэлтгэсэн хугацаа	
-------------------	--

д.д	ТЭЭГЧИЙН МЭДЭЭЛЭЛ							
	Хувийн дугаар	үүлдрийн код	ороо орсон хугацаа	хөврөлийн хөгжлийн үе шат	чанарын үнэлгээ	хөврөлийн дугаар	хөвөл суулгасан хугацаа	тэмдэглэл
1								
2								
3								
4								
5								
6								
7								
8								

гарын үсэг		АА-н нэр	
		утасны дугаар	

Хөврөл шилжүүлэн суулгасан гэрчилгээнд шилжүүлэн суулгасан тээгчийн талаарх мэдээлэлийг үнэн зөв бөглөж оруулна. Хэрэв гүн хөлдөөж хадгалсан хөврөлийг шилжүүлэн суулгаж байгаа бол тус хөврөлийн гарал үүслийн гэрчилгээн дэхь мэдээлэлийг бүрэн бөглөсөн байна./эсэхийг шалгана/ Хөврөл шилжүүлэн суулгасан техникч нь шилжүүлсэн хөврөлийн болон тээгчийн талаарх мэдээлэлийг бүрэн гүйцэт оруулна. Ороо орсноос хойших өдрийг хугацааг тооцохдоо өдрийн 1/2 -ээр тооцно.

3. ГҮН ХӨЛДӨӨСӨН ХӨВРӨЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Гүн хөлдөөж хадгалсан хөврөлийн гэрчилгээнд хөврөлийг зайлж авсан болон хөлдөөж хадгалсан хугацааг гүйцэт бөглөнө. Гэрчилгээ нь мэргэжилтэний гарын үсгээр баталгаажсан байна. Хөврөл гүн хөлдөөж хадгалсан тухай гэрчилгээг 2 хувь үйлдэж эх хувийг МУСҮТөвд, хуулбар хувийг тухайн донор малыг эзэмшигч иргэн, аж ахуйд хүлээлгэн өгнө.

Хөврөлийг худалдан борлуулсан тохиолдолд эзэмшигч солигдсон, шилжүүлэн суулгасан тухай мэдээлэлийг МУСҮТөв болон тухайн сум, дүүргийн ХАА-и тасгийн бүртгэл хариуцсан мэргэжилтэнд бүртгүүлнэ.

Гүн хөлдөөсөн хөврөлийн импортлох, экспортлох бол тухайн аймаг, сум, дүүргийн ХАА-н тасгаас зөвшөөрөл авсаны дараа МУСҮТөвөөс зөвшөөрөл авч үржүүлэгт ашиглах эрхтэй болно.

ГҮН ХӨЛДӨӨСӨН ХӨВРӨЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

азотын савны дугаар:		бортогоны дугаар		Бусад мэдээлэл		AA-н код, үүлдрийн код, донорын дугаар, хөлдөөсөн онгоо, гуурсны дугаар	
Азотын савны дугаар	бортогоны дугаар	хөврөлийн гуурсны дугаар	Угаасан хөврөлийн тоо	хөгжлийн үнэлгээ	чанарын үнэлгээ	бүрхүүлийн үнэлгээ	тэмдэглэл
				хөлдөөснөөс хойш гэсгээх хугацаа/цагаар/			
гарын үсэг			AA-н нэр				
				утасны дугаар			

4. Гэрчилгээнд хөврөлийн мэдээлэлийг оруулахдаа дараах түлхүүрийг /кодыг/ ашиглана.

Хөврөлийн хөгжлийн үе шатны үнэлгээ		Хөврөлийн чанарын үнэлгээ		Сарын тэмдэглэгээ	
Тэмдэглэгээ	Үе шат	Тэмдэглэгээ	Чанарын үзүүлэлт	Тэмдэглэгээ	Сарууд
1	Үр тогтоогүй	Code -1	Маш сайн	JA	I сар
2	2-12 бластомертэй	Code -2	Сайн	FE	II сар
3	Эртний морула	Code -3	Дунд	MR	III сар
4	Морула	Code -4	Муу, үхсэн	AP	IV сар
5	Эртний бластоцит			MY	V сар
6	Бластоцит			JN	VI сар
7	Тэлсэн бластоцит			JY	VII сар
8	Задарсан бластоцит			AU	VIII сар
9	Задарч тэлсэн бластоцит			SE	IX сар
				OC	X сар
				NO	XI сар
				DE	XII сар

Үүлдрийг дараах түлхүүр үгээр тэмдэглэнэ.

Үхрийн үүлдрүүд	ER - Eringer	NG - Nguni
AN - Aberdeen Angus	FA - Flamand	NM - Normande
AB - Abondance	FL - Fleckvieh	NR - Norwegian Red
AF - Afrikaner	FR - Fribourg	PA - Parthenais
AK - Ankole	FB - Friesian (Belgian)	PI - Piedmont
AY - Ayrshire	DF - Friesian (Dutch)	PR - Pie Rouge
BA - Barzona	GA - Galloway (beef)	PZ - Pinzgauer
BE - Beefalo	GD - Galloway (dairy)	RA - Ranger
BF - Beef Friesian	GS - Gascone	AR - Red Angus
BM - Beefmaster	GV - Gelbvieh	RB - Red Brangus
BB - Belgian Blue	GI - Gir	RD - Red Dane (Red Danish, Danish Red)
BG - Belted Galloway	GR - Groninger	WW - Red Holstein
BD - Blonde D'Aquitaine	GU - Guernsey	RP - Red Poll
BX - Boran	GZ - Guzera	RN - Romagnola
BO - Braford	HC - Hays Converter	RO - Rotbunte
BR - Brahman	HH - Hereford (horned)	SA - Salers
BH - Brahmental	HP - Hereford (polled)	SG - Santa Gertudis
BL - Braler	SH - Highland (Scotch Highland)	SE - Senapol
BN - Brangus	HO - Holstein	SL- SELENGE
BU - Braunvieh	HY - Hybrid (Alberta Hybrid)	MS - Shorthorn (milking)
SB - Brown Swiss (beef)	IB - Ibage	SS - Shorthorn (beef - Scotch)
BS - Brown Swiss (dairy)	IN - Indu Brasil	SP - Shorthorn (polled)
BZ - Bonsmara	JE - Jersey	IS - Shorthorn (Illawarra)
CP - Campine Red Pied	KB - Kobe (Wagyu)	SI - Simbrah
CN - Canadienne	LU - Luing	SM - Simmental
CB - Charbray	LM - Limousin	DS - South Devon
CH - Charolais	LR - Lincoln Red	SX - Sussex
CA - Chianina	MA - Maine-Anjou	TA - Tarentaise
DB - Danish Black & White	MR - Marchigiana	TG - Tasmanian Grey
DJ - Danish Jersey	ME - Maremmana	TL - Texas Longhorn
RW - Danish Red & White	MI - Meuse Rhine Issel	TU - Tuli
DE - Devon	MO - Montbeliard	WB - Welsh Black
DT - DORNOD TALIIN BEEF CATTLE	MN - MOGOLIAN NATIVE BREED	WF - West Flemish Red
DR - Dexter	MG - Murray Grey	XX - Crossbreds
DZ - Drakensberger	NE - Nelore	
FP - East Flemish Red Pied		

Ямааны үүлдрүүд

AL – Alpine

AU – ALTAI ULAAN

TO - Toggenburg

AG - Angora

SA - Saanen

CH – Cashmere

GG- GOVI GURVAN SAIKHAN

MN – MONGOLIAN NATIVE BREED

BG – Boer

BU – BAYANDELGERIIN ULAAN

KR - Kalahari Reds

LN - La Mancha

NU - Nubian

SG - Savanna Goat

UB – UULIIN BOR

ZB – ZAVKHAN BUURAL

ZJ – ZALAA JINST IDREN

Адууны үүлдрүүд

AS - American Saddlebred

AP - Appaloosa

AB - Arabian

BL - Belgian

CL – Clydesdale

GS – GAL SHAR

HA - Hackney (Horse)

HK - Hackney (Pony)

HU - Hunter

MN – Morgan

ML- MONGOLIAN NATIVE

PL - Palomino

PE - Percheron

PN - Pinto

QH - Quarter Horse

SE - Shetland

SI - Shire

SN - Standardbred

SF - Suffolk Punch

TW - Tennessee Walking

TH - Thoroughbred

WE – Welsh